

BASALTWOOL®
МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

2024 оны хагас жилийн

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**Оноосон нэр:**

Монгол Базальт ХК

**Үйл ажиллагааны чиглэл:**

Чулуун хөвөнгийн үйлдвэр,
үйлдвэрийн хүчин чадал: **Цагт 2.5 тн**

**Байгуулагдсан огноо:**

2007

**Хаяг:**

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Фламинго тауэр, 403 тоот

**Вэбсайт, фэйсбүүк хаяг:**

www.basaltwool.mn
Mongol Basalt JSC

**Утас, и-майл хаяг:**

75114444
monbasalt@rockwool.mn

## УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦ

**ТУЗ-ийн дарга:**

Л.Ариунболд

**Гүйцэтгэх захирал:**

А.Энхгэрэл

**Ажилчдын тоо:**

83

## ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

**Хувьцааны симбол код:**

MSE:MBW / 544

**МХБиржид бүртгэгдсэн:**

2018.04.05

**Нийт гаргасан хувьцаа:**

56,417,000 ширхэг





## АЛСЫН ХАРАА

Галт уулын чулуулгийг чулуун хөвөн болгон хувиргаж, нийгэмд тулгарч буй уур амьсгалын өөрчлөлтийн томоохон сорилтуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэж, орчин үеийн амьдралыг баяжуулж, аюулгүй, эрүүл, уур амьсгалд илүү тэсвэртэй, тотвортой нийгмийг цогцлооно.



## ЭРХЭМ ЗОРИЛГО

Инноваци шингэсэн үйлдвэрлэл технологиороо салбараа манлайлан хөгжүүлж, хүний амьдрах орчинг тав тухтай, барилга хийцийн эрсдэлгүй, байгальд хамгийн ойр байлгаж, ирээдүй хойчдоо өвлүүлэн үлдээх үнэ цэнэ бүхий баталгаат хөрөнгө оруулалтыг бий болгоно.

## ТОВЧ ТҮҮХ



**2007**

Монгол Базальт ХК-ийн ТУЗ-ийн дарга, үүсгэн байгуулагч Л.Ариунболд Чулуун хөвөнгийн үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулсан.

**2009**

Чулуун хөвөнгийн үйлдвэр байгуулж, анхны бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлсэн.





**2013**

Дулааны шугам хоолойн дулаалга үйлдвэрлэх СТУ дулаалгын технологийг нэвтрүүлж, Термобазальт үйлдвэрийг байгуулсан.

**2019**

Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг өрнүүлж, хүчин чадлаа 1.5 дахин нэмэгдүүлсэн. Базальт чулуун хөвөн хөрсний судалгаа эхлүүлсэн





**2021**

Чулуун хөвөнд суурилсан инновацийн Базальт арматур, Базальт сэндвич, Грөвүүл 3 төсөл амжилттай хэрэгжүүлсэн.

**2022**

Базальт файбер арматур үйлдвэрлэх технологийг нэвтрүүлж, Монголын анхны базальт файбер арматурын үйлдвэр байгуулсан.





**2023**

Базальт кассет сэндвич хавтан үйлдвэрлэх технологийг боловсруулж, үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн.

**BASALTWOOL®**
**МОНГОЛ БАЗАЛЬТ ХК**



## ТАНЫ ДУЛААЛГЫН ТӨГС ШИЙДЭЛ

- НАСЖИЛТ 100 ЖИЛ
- ЭКО БҮТЭЭГДХҮҮН
- ДУУ ЧИМЭЭ ТУСГААРЛАНА
- ХАЛУУН ХҮЙТЭН ТУСГААРЛАНА
- ГАЛД ШАТДАГГҮЙ
- БАТ БЭХ ТОГТВОРТОЙ



# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, ур дүнтэй бүтэц байхаар Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн зарчмыг баримтлан ажиллаж байгаа бөгөөд цаашид Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг хангах, хэвшүүлэх, тогтвортой байдлыг бий болгох зорилттойгоор ажиллана.

ТУЗ нь 2023 онд танхим цахим хосолсон, эчнээ санал хураалтын хэлбэрээр нийт 6 удаа ирц бүрэн хуралдаж, 21 тогтоол, шийдвэр гаргасан.

## ТУЗ-ИЙН ХОРООД

1. Нэр дэвшүүлэх хороо
2. Аудитын хороо
3. Цалин урамшууллын хороо
4. Эрсдлийн удирдлагын хороо

## 1 ТУЗ-ийн бүрэлдэхүүн


Л.Ариунболд


Б.Шаравсамбуу


Хан Гю Бунг


П.Сайнбилэг


Г.Ганзориг


А.Энхгэрэл


Ш.Энхтөр


П.Нямдорж


Ч.Зоригтбаатар

## 2 Бодлогын баримт бичиг

Шинээр боловсруулж баталсан бодлогын баримт бичиг:

| Баримт бичгийн нэр |
|---|
| Бизнесийн ёс зүйн дүрэм |
| Эрсдлийн удирдлагын хорооны журам |
| Эрсдлийн удирдлагын бодлого |
| Залгамж халааны бодлого |
| Цалин урамшууллын бодлого |
| Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого |

**Компанийн засаглалын кодексын үнэлгээ:**

98.6%

# ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

## ХУВЬЦААНЫ ХАНШ

**Хаалтын ханш**
**/2024.06.30/**

**189.98₮**

**-2.02₮**

**192₮**

**Өмнөх ханш**
**/2023.12.31/**

## ХУВЬЦААНЫ ХАНШИЙН ГРАФИК




Тайлант хугацаанд хоёрдогч зах зээлд арилжаалагдсан нийт хувьцааны дээд ханш нь 206₮, доод ханш нь 170.42₮ бөгөөд 2024 оны эхний хагас жилийн хаалтын ханш 189.98₮ байлаа.

Тайлант хугацаанд үнэт цаасны хоёрдогч зах зээлд сард дунджаар 225 мянган ширхэг буюу тайлант хугацааны туршид нийт 1350 мянган ширхэг хувьцаа 246.1 сая төгрөгөөр арилжаалагдлаа.

Монгол Базальт ХК 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгууллаа. Мөн тус компани нь Санхүүгийн зохицуулах хорооны “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” тогтоолд 2024 оны 02 сарын 23-ны өдөр өөрчлөлт оруулсантай холбогдуулан 2023 оны ногдол ашиг болох 1,184,757,000 төгрөгийг ҮЦТХТ ХХК-р дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд 2024 оны 05 сарын 31-ний өдөр тараан байршууллаа.

## 1 Хувьцаа эзэмшигчдийн бүтэц




## 2 Нөлөө бүхий хувьцаа эзэшигчид

| № | Нэр | Нийт хувьцаанд эзлэх хувь |
|---|---|---|
| 1 | Л.Ариунболд | 35.7% |
| 2 | П.Сайнбилэг | 13.3% |
| 3 | А.Энхгэрэл | 7% |
| 4 | А.Энхмаа | 7% |
| 5 | А.Энхжин | 7% |

# ХҮНИЙ НӨӨЦ

2019-2024 оны хооронд тогтвортой ажлын байрны өсөлт 40% байгаа ба шинээр базальт кассет сэндвич хавтангийн үйлдвэр ашиглалтанд оруулснаар ажлын байрны тоо хэмжээ 2 дахин өснө. Нийт ажилтны 80% нь дээд боловсролтой болон МСҮТ төгссөн, 70% нь 3 жилээс дээш хугацаанд ажилласан нь хүний нөөцийн тогтвортой, чадварлаг баг бүрдсэнийг илтгэж байна. Хүний нөөцийн эргэцийн дундаж хувь **2.6%**-тай буюу хүний нөөц тогтвор суурьшилтай байгааг харуулж байна.



Эх сурвалж: Цэцэгт нуга амралтын газарт-2023 оны сургалт семинарын үеэр

### Хүйсийн харьцаа



Эрэгтэй **65%**

Эмэгтэй **35%**

### Хүний нөөцийн харьцуулалт




### Цалингийн сангийн харьцуулалт /сая төгрөг/




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16% өссөн

# ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол базальт ХК-ийн дулаан тусгаарлагч материалын үйлдвэр нь 2024 оны эхний хагас жилийн байдлаар 1,323 тонн хөвөн үйлдвэрлэлээ.

Шугам хоолойн дулаалгын цехэд нийт 4001 метр шугам, яндан хоолойн дулаалга хийж гүйцэтгэлээ. Чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалын үйлдвэрт их бүтээн байгуулалт засвар шинэчлэлийн ажил өрнүүлж, тоног төхөөрөмжийн туршилт тохируулгын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Цаашид бид хавтангийн чанарт онцгой анхаарч технологийн горимыг өндөр түвшинд мөрдүүлж, хүн хүчний нөөц суурийг бэлтгэх сургах, хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлыг чанад мөрдөж ажиллана.






# САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үйлдвэрлэлийн шинэчлэл инновацийн үр дүнд чулуун хөвөн хавтангийн борлуулалтын үнээ 30-51% бууруулан хэрэглэгчдэд хүргэж байна. 2023 оны мөн үетэй харьцуулахад борлуулсан бүтээгдэхүүний тоо өсч, борлуулалтын орлого 31.5% өссөн үзүүлэлттэй байна.

**БОРЛУУЛАЛТ / САЯ.ТӨГРӨГ**




Монгол Базальт ХК нь 2024 оны эхний хагас жилд зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангах зорилгоор их бүтээн байгуулалтыг өрнүүлж үйлдвэрлэлийн шугам дамжлагаа хүчитгэн ажилласны үр дүнд 137 мянга орчим боодол бүтээгдэхүүн борлуулсан байна.

Нийт борлуулсан бүтээгдэхүүний 68%-ийг базальт лайт, 15%-ийг базальт хауз,12%-ийг базальт вэнт фасад, 5%-ийг базальт техно стандарт марк тус тус эзэлж байна. Энэхүү үзүүлэлт нь хувь хэрэглэгчидийн худалдан авалт идвэхитэй байгааг илэрхийлж байна.

**Олгосон ногдол ашиг**

| Он | Нийт ногдол ашиг | Цэвэр ашигт эзлэх % | Нэгж хувьцаанд ногдох /₮/ | Ногдол ашгийн өгөөжийн % |
|---|---|---|---|---|
| 2019 | 225,668,000.00 | 68% | 4.00 | 2% |
| 2020 | 162,480,960.00 | 100% | 2.88 | 2% |
| 2021 | 964,166,530.00 | 60.2% | 17.09 | 10% |
| 2022 | 1,128,340,000.00 | 53.4% | 20 | 9% |
| 2023 | 1,184,757,000.00 | 96.1% | 21₮ | 10.2% |

**Ногдол ашгийн өсөлт /₮/**



# САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

| | Тайлант үе: | 2024/01/01 - 2024/06/30 | |
|---|---|---|---|
| | | | /төгрөгөөр/ |
| Балансын зүйл | | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
| ХӨРӨНГӨ | | 0.00 | 0.00 |
| Эргэлтийн хөрөнгө | | 0.00 | 0.00 |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | | 5,760,907,762.33 | 3,588,401,504.03 |
| Дансны авлага | | 11,528,170.06 | 37,639,645.06 |
| Татвар, НДШ-ийн авлага | | 173,118.44 | 228,079.48 |
| Бусад авлага | | 192,512,446.50 | 196,782,735.83 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | | 0.00 | 0.00 |
| Бараа материал | | 2,933,428,573.44 | 4,274,179,316.20 |
| Урьдчилж төлсөн зардал тооцоо | | 2,822,862,258.79 | 4,699,895,665.22 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | | 0.00 | 0.00 |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | | 0.00 | 0.00 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | | 11,721,412,329.56 | 12,797,126,945.82 |
| Эргэлтийн бус хөрөнгө | | 0.00 | 0.00 |
| Үндсэн хөрөнгө | | 18,099,192,849.66 | 17,456,119,769.85 |
| Биет бус хөрөнгө | | 11,911,039,441.76 | 11,655,251,661.81 |
| Биологийн хөрөнгө | | 0.00 | 0.00 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | | 1,945,863,146.22 | 1,945,863,146.22 |
| Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | | 0.00 | 0.00 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | | 0.00 | 0.00 |
| Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | | 0.00 | 0.00 |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | | 0.00 | 0.00 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | | 31,956,095,437.64 | 31,057,234,577.88 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | | 43,677,507,767.20 | 43,854,361,523.70 |
| ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | | 0.00 | 0.00 |
| ӨР ТӨЛБӨР | | 0.00 | 0.00 |
| Богино хугацаат өр төлбөр | | 0.00 | 0.00 |
| Дансны өглөг | | 245,144,177.18 | 131,035,168.09 |
| Цалингийн өглөг | | 575,550.00 | 70,456,310.73 |

| | Тайлант үе: | 2024/01/01 - 2024/06/30 | |
|---|---|---|---|
| Татварын өр | | 1,329,657,233.48 | 1,540,107,036.11 |
| НДШ-ийн өглөг | | 54,618.45 | 43,660,394.46 |
| Богино хугацаат зээл | | 504,000,000.00 | 1,975,541,007.05 |
| Хүүний өглөг | | 0.00 | 0.00 |
| Ногдол ашгийн өглөг | | 729,846,100.00 | 0.00 |
| Урьдчилж орсон орлого | | 488,447,013.25 | 438,398,024.02 |
| Нөөц / өр төлбөр / | | 345,288,489.39 | 518,771,750.15 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | | 3,078,159.02 | 3,061,010.42 |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ( борлуулах бүлэг хөрөнгө )- нд хамаарах өр төлбөр | | 0.00 | 0.00 |
| ... | | 0.00 | 0.00 |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | | 3,646,091,340.77 | 4,721,030,701.03 |
| Урт хугацаат өр төлбөр | | 0.00 | 0.00 |
| Урт хугацаат зээл | | 8,500,000,000.00 | 8,193,956,164.38 |
| Нөөц / өр төлбөр/ | | 0.00 | 0.00 |
| Хойшлогдсон татварын өр | | 0.00 | 0.00 |
| Бусад урт хугацаат өр төлбөр | | 0.00 | 0.00 |
| ... | | 0.00 | 0.00 |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | | 8,500,000,000.00 | 8,193,956,164.38 |
| Өр төлбөрийн нийт дүн | | 12,146,091,340.77 | 12,914,986,865.41 |
| Эздийн өмч | | 0.00 | 0.00 |
| Төрийн өмч | | 0.00 | 0.00 |
| Хувийн өмч | | 5,641,700,000.00 | 5,641,700,000.00 |
| Хувьцаат өр төлбөр | | 0.00 | 0.00 |
| Халаасны хувьцаа | | 0.00 | 0.00 |
| Нэмж төлөгдсөн капитал | | 20,509,765,227.48 | 20,509,765,227.48 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | | 1,429,273,949.00 | 1,429,273,949.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | | 0.00 | 0.00 |
| Эздийн өмчийн бусад хэсэг | | 890,145,164.30 | 890,145,164.30 |
| Хуримтлагдсан ашиг | | 3,060,532,085.65 | 2,468,490,317.51 |
| ... | | 0.00 | 0.00 |
| Эздийн өмчийн дүн | | 31,531,416,426.43 | 30,939,374,658.29 |
| ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | | 43,677,507,767.20 | 43,854,361,523.70 |

## САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

| | | |
|---|---|---|
| Тайлант үе: | | 2024/01/01 -2024/06/30 |
| | | /төгрөгөөр/ |
| Үзүүлэлт | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
| Борлуулалтын орлого ( цэвэр ) | 10,019,108,280.58 | 5,017,395,773.98 |
| Борлуулалтын өртөг | 6,886,199,332.99 | 3,118,764,584.81 |
| Нийт ашиг ( алдагдал ) | 3,132,908,947.59 | 1,898,631,189.17 |
| Түрээсийн орлого | 0.00 | 0.00 |
| Хүүгийн орлого | 78,984,860.95 | 135,594,176.37 |
| Ногдол ашгийн орлого | 0.00 | 0.00 |
| Эрхийн шимтгэлийн орлого | 0.00 | 0.00 |
| Бусад орлого | 54,376,330.65 | 447,366.42 |
| Борлуулалт, маркетингийн зардал | 912,402,809.50 | 621,215,211.66 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 441,373,948.41 | 266,935,118.34 |
| Санхүүгийн зардал | 530,890,212.86 | 627,156,032.48 |
| Хөрөнгө оруулалтын зардал | 0.00 | 0.00 |
| Бусад зардал | 7,670,000.00 | 26,450,000.00 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз ) | -4,680,321.97 | 75,615,136.84 |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз ) | 0.00 | 0.00 |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны олз ( гарз ) | 0.00 | 0.00 |
| Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз ( гарз ) | 0.00 | 0.00 |
| Бусад ашиг ( алдагдал ) | 0.00 | 0.00 |
| Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал ) | 1,369,252,846.45 | 568,531,506.32 |
| Орлогын татварын зардал | 136,925,284.65 | 56,860,541.26 |
| Татварын дараах ашиг ( алдагдал ) | 1,232,327,561.80 | 511,670,965.06 |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг ( алдагдал ) | 0.00 | 0.00 |
| Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал ) | 1,232,327,561.80 | 511,670,965.06 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 1,569,922,865.71 | 0.00 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү | 1,569,922,865.71 | 0.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 |
| Бусад олз ( гарз ) | 0.00 | 0.00 |
| Орлогын нийт дүн | 2,802,250,427.51 | 511,670,965.06 |
| Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал ) | 0.00 | 0.00 |



## Сургалт

Монгол Базальт ХК нь 2024 оны 01 сард Дархан уул аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Дархан уул аймгийн эмэгтэйчүүдийн холбоотой хамтран Утаагүй Дархан төслийн хүрээнд Термохаус Пассив сургалтын төвийг байгуулж Агаар орчны бохирдлыг бууруулах дахин дулаалгын болон Пассив барилгын сургалтуудыг МУИС-ын Амарбаяр профессортой хамтран 2 удаа зохион байгуулаад байна.

## TedxDarkhan

Компанийн гүйцэтгэх захирал А.Энхгэрэл TedxDarkhan Salon “ReImagine” арга хэмжээний илтгэгчээр оролцож, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх арга барилаа ШИНЭЭР ТӨСӨӨЛСНӨӨР хэрхэн БИД БҮГДЭД бий нөөцүүдийг хөшүүрэг болгон ашиглах боломжтой талаар туршлагаасаа хуваалцлаа. Арга хэмжээний үеэр Монгол Базальт ХК мэдээлэл бүтээгдэхүүн, үйлчилгээгээ Дархан хотын иргэдэд танилцууллаа.

## Улаанбаатар барилга-2024

“Мишээл Экспо”-с жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Улаанбаатар Барилга-2024 үзэсгэлэн арга хэмжээнд амжилттай оролцлоо.

Уг үзэсгэлэн арга хэмжээ нь 2 төрөл буюу Барилга орон сууц, Барилгын материал шинэ технологи гэсэн сэдвүүдээр зохион байгуулагдаж нийт 3000 гаруй хэрэглэгчдэд мэдээлэл зөвлөгөөг хүргэлээ.








## Barilga Expo-2024

Барилга.мн-ээс жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “BARILGA EXPO” барилгын үзэсгэлэн яармаг “Build smart …” уриа дор 2024 оны 04 сарын 12-14-ны өдрүүдэд “Буянт – Ухаа” ордонд болсонб а Монгол Базальт ХК амжилттай оролцож, хэрэглэгчдэд мэдээлэл зөвлөгөө өгч, Барилгын салбарын 500 орчим шилдэг аж ахуй нэгж байгууллага, 32 000 гаруй үзэгч, хэрэглэгчидэд хүрч ажиллаа.




## "Build Mongolia 2024

""Монгол орноо хамтдаа бүтээн байгуулцгаая” уриан дор Build Mongolia 2024 - Олон улсын барилга, уул уурхай, эрчим хүч, дэд бүтэц, дэвшилтэт технологийн 4 дэх удаагийн үзэсгэлэн 2024 оны 4 сарын 24-26ны өдрүүдэд Степпе-Арена буюу Мөсөн Өргөөнд амжилттай зохион байгуулагдаж Монгол Базальт ХК амжилттай оролцлоо.




## “ДАРХАН БАРИЛГА ЭКСПО”-2024

Дархан- Уул аймгийн барилгын салбарын хамгийн том “ДАРХАН БАРИЛГА ЭКСПО” цуврал үзэсгэлэнд Монгол Базальт ХК оролцож Дархан-Уул аймгийн хэрэглэгчдэдээ ойртон очиж дахин дулаалгын зөвлөгөө мэдээллийг хүргэж ажиллалаа.



## Инновац, Эрчим хүчний үр ашиг, сэргээгдэх эрчим хүчний олон улсын үзэсгэлэн

Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ, эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх сүүлийн үеийн технологийг танилцуулж, салбарын мэргэжилтнүүдийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэх IREEE 2024 Инновац, сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашгийн олон улсын үзэсгэлэн, конференцыг Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хорооноос санаачлан USAID-ын дэмжлэгтэйгээр Нийслэлийн инновацийн газар, МҮХАҮТ-тай хамтран 2024 оны 5 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Мишээл экспод зохион байгуулсан ба Монгол Базальт ХК амжилттай оролцож **Шилдэг** байгууллагаар тодорлоо.

## “ШИНЖЛЭХ УХААНД СУУРИЛСАН ХӨГЖЛИЙН ТҮНШЛЭЛ” ФОРУМ 2024

Инновацад суурилсан хөгжлийн төлөөх түншлэлийн форум нь Дархан-Уул аймгийн төдийгүй Төвийн бүсийн хэмжээнд тулгамдаж буй сорилтуудыг шийдвэрлэхийн тулд төр, хувийн хэвшил, их сургууль, шинжлэх ухааны байгууллагууд нэгдэн хамтын ажиллагаагаа өрнүүлэх, шинэлэг шийдлүүдийг хамтран бүтээх платформыг бий болгох явдал юм.
Тус форумын үеэр Монгол Базальт ХК-ийн гүйцэтгэх захирал А.Энхгэрэл Зочин илтгэгчээр оролцож "Чадамжтай хүний нөөц бий болгоход тулгамдаж буй асуудал, шийдэл” сэдвээр илтгэл тавилаа.

## "МОНГОЛ ИНЖЕНЕР"-2024

Энэхүү үйл ажиллагаа нь оюутан залуус, багш судлаач, инженерүүдийн мэдлэг, ур чадвар, инженерчлэлийн оновчтой шийдлийг дэмжих, судалгааны ажлын үр дүнг түгээн дэлгэрүүлэх, бизнесийн байгууллага - их, дээд сургуулийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой. “МОНГОЛ ИНЖЕНЕР-2024” нэгдсэн үйл ажиллагааны хүрээнд CAD/CAE/CAM улсын олимпиадыг амжилттай зохион байгуулсан ба Монгол Базальт ХК ерөнхий ивээн тэтгэгчээр оролцож, Монгол Базальт ХК-ийн инженерүүд шүүгчээр ажиллаа.









## “НОГООН ХОТ МИНИЙ ИРЭЭДҮЙ” гар зургийн уралдаан

Монгол Базальт ХК-ийн жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Ногоон хот миний ирээдүй сэдэвт гар зургийн уралдааныг 6-12 насны хүүхдүүдийн дунд амжилттай зохион байгуулж шилдэг 20 бүтээлийг мэргэжлийн шүүгчдийн бүрэлдэхүүнээр шалгаруулж, шагналыг гардууллаа.



## "ФЭЙСБҮҮК АЗТАН” -2024

"Хилэнт эх” хэмээх Модон Луу жилийн Сар шинийн баярт зориулсан “ФЭЙСБҮҮК АЗТАН” шалгаруулах 3.5 сая төгрөгийн базальт чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалын шагналтай уралдааныг зохион байгууллаа.




## Монгол Базальт ХК Барилгын Дэлхийн Холбоонд (GlobalABC) гишүүнээр элслээ.

GlobalABC нь олон улсын, олон талт түншлэл бөгөөд янз бүрийн платформ, санаачлага, оролцогчдын хамтарсан байгууллага юм. Энэ нь Парисын хэлэлцээрийн зорилтуудын дагуу хамтын ажиллагааг бий болгох, уур амьсгалын үйл ажиллагааг өргөжүүлэх, барилга байгууламж, барилгын салбарын уян хатан байдлыг нэмэгдүүлэх зорилготой юм.



# ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Монгол Базальт ХК нь НҮБ-ын “Даян дэлхийн гэрээ” болон Тогтвортой санхүүжилтийн холбоонд үүрэг, амлалт хүлээн нэгдэн орохоор зэхэж, бизнес ба хүний эрхийн зарчим, шаардлагуудыг компанийн менежментийн үйл ажиллагаанаас эхлэн өдөр тутмын үйл ажиллагаанд шат дараалан нэвтрүүлэн ажиллаж байна.




Тус компанийн үйл ажиллагаа болон үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн Тогтвортой хөгжлийн 17 зорилгуудын 12-ийн хэрэгжилтэд хувь нэмэр оруулж байна.

Чулуун хөвөн дулаалгын материалын үйлдвэрлэлээр тэргүүлэгч "Монгол базальт" ХК нь байгаль орчны хариуцлагын төлөөх амлалтаа биелүүлэхийн тулд тогтвортой хөгжлийн хэд хэдэн санаачилга хэрэгжүүлсэн. Тус компанийн эрхэм зорилгын дагуу галын аюулгүй байдал, эрчим хүчний хэмнэлт, тав тухыг хангах тогтвортой шийдлүүдийг санал болгохын сацуу тогтвортой хөгжил, дахин боловсруулалтын хэд хэдэн гол санаачлагыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Тус компани нь байгаль орчны тогтвортой байдалд хувь нэмэр оруулах, дугуй эдийн засгийн зарчимд нийцүүлэх зорилготой чулуун хөвөнгийн хаягдлыг дахин боловсруулах хөтөлбөрийг эхлүүлсэн.




SDG 17:
үр дүнтэй хамтын ажиллагаанд оролцох
SDG 13:
Нүүрс хүчлийн хий бага ялгаруулах барилга, байгууламж үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭ
SDG 7:
Үйлдвэрийн болон оффисын барилгын фасад засвар шинэчлэл хийж эрчим хүчний хэмнэлттэй болсон
SDG 6:
Ашигласан усны нөөцийн сан байгуулж усны дахин хэрэглээг нэвтрүүлж үйлдвэрт саарал усыг хэрэглээнд оруулсан
SDG 13:
Үйлдвэрийн гарах хоолойн уудын филтер системийг дахин сайжруулж нүүрс хүчлийн хийн ялгаралыг стандартаас бага хэмжээнд хүргэсэн
SDG 8:
Аюулгүй ажиллагааг сайжруулж, сул зогсолтыг бууруулсан
SDG 9:
Бат бөх, гал тэсвэртэй барилга байгууламжийг нэмэгдүүлэх
SDG 8:
Тогтвортой ажлын байр, эдийн засгийн өсөлтийг дэмжих
SDG 13:
Нүүрстөрөгчийн хэмнэлттэй барилга, байгууламж үйлдвэрлэлийг идэвхижүүлэх
SDG 11:
Оролгод нийцсэн орон сууц, эрчим хүчний хэмнэлтийг дэмжих
SDG 7:
Эрчим хүчний хэмнэлттэй барилга, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
SDG 6:
Тариалалтын усны хэрэглээг багасгах
SDG 2:
Тогтвортой хүнсний үйлдвэрлэлийг бий болгох
SDG 12:
Хог хаягдалгүй үр ашигтай үйлдвэрлэл
SDG 3:
Дуу чимээний тусгаарлалттай барилга байгууламжийг нэмэгдүүлэх
GROWOOL
SUSTAINABLE GROWING
Тогтвортой хөгжлийн зорилт
Бүтээгдэхүүний хэмжүүр

## SDG 12: NET ZERO
## BASALTCycling Roadmap




SDG 13:
Нүүрстөрөгчийн хэмнэлттэй барилга, байгууламжийн үйлдвэрлэлийг дэмжих

SDG 11:
Хямд үнэтэй орон сууц, эрчим хүчний хэмнэлтийг дэмжих

SDG 7:
Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх

SDG 3:
Дуу чимээний тусгаарлалттай барилга байгууламжийг нэмэгдүүлэх

Монгол Базальт ХК нь өндөр чанарын, ногоон барилгын дулаалгын материалуудыг Европын Холбооны галын A1 зэрэглэлийг хангаж нийлүүлж байна. Хариуцлагатай барилгын салбарыг Инновациар дэмжинэ.

# НОГООН ТӨСӨЛ GROWOOL

SUSTAINABLE DEVELOPMENT GOALS
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГА

Чулуун хөвөн ашиглан гидропоник технологиор тариалалт хийх нь байгаль цаг уураас хараат бус жилийн дөрвөн улирал тогтвортой ургац хураах боломжыг бүрдүүлэх болно.
Монгол Базальт ХК-ийн хамт олон анхны монгол хэл дээрх хөрсгүй тариалалтын гидропоник технологийн зааварчилгаа, гарын авлага номыг бэлтгэн, 2021 оны 11 сард худалдаанд гаргасан.

Монгол Базальт ХК нь 2019 оноос GROWOOL /ургамал тарих чулуун хөвөн/ старт апыг бойжуулан хадгалалт тээвэрлэлтээс үүсэх хүнсний ногооны хаягдалыг багасгах, усны хэрэглээ бага тариалалтын технологийг нэвтрүүлэх, хуурай сэрүүн уур амьсгалтай Монгол орны нөхцөлд байгаль цаг уураас хараат бус жилийн турш тогтвортой тариалалт хийх боломжтой шинэ технологи болох гидропоник технологийн талаар сургалт зөвлөгөө, гарын авлага, мэдээллийг иргэд аж ахуй нэгж, нийгэмд түгээн ажиллаж байна. 2023 онд төслийг өргөжүүлэн 4 улирлын гидропоник хүлэмж байгуулах ажлыг эхлүүлсэн ба 2024 онд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөөд байна.





### ТОГТВОРТОЙ ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Монгол улсын хүнсний ногооны 80%-г импортын бүтээгдэхүүн эзлэж байна. COVID-ын нөлөөгөөр монгол улсад өргөн хэрэглээний хүнсний ногооны үнэ нэмэгдэж, хомсдол бий болж буй энэ цаг үед бид иргэн бүр хүнсний ногоогоо өөрөө ургуулах боломжтойг сурталчилан таниулж байна.

Монгол улсын цэвэр усны хэрэглээний 12%-г усалгаатай тариалан буюу газар тариаланд ашигладаг бөгөөд базальт чулуун хөвөн ашигласнаар газар тариаланд ашиглаж буй усыг 80-90%, тариалалтын талбайн хэмжээг 70% хүртэл хүртэл бууруулах бүрэн боломжтой юм.

Мөн жилийн дөрвөн улиралд уур амьсгал, цаг агаарын нөлөөлөлөөс шалтгаалахгүйгээр тогтвортой хүнс үйлдвэрлэх боломжтой тул тогтвортой хөгжлийн зорилтын 2, 6 болон 15 дугаар зорилтуудыг бүрэн хангаж чадсан **НОГООН** төсөл юм.












## Social Media

Mongol Basalt JSC

Mongol_Basalt

www.basaltwool.mn

## Contact

monbasalt@rockwool.mn

+976 75114444, 77006768

БГД, 20-р хороо,
үйлдвэрийн тойруу 132,
Улаанбаатар, Монгол улс

*Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 сарын*
*11-ний 225 дугаар тогтоолоор батласан*
*“Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дөрөвдүгээр хавсралт*

# МОНГОЛ БАЗАЛЬТ ХК

## 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан

| | |
|---|---|
| *Тайлагнах хугацаа* | 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 6 дугаар сарын 30-ний өдөр |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | Нэр: Монгол базальт ХК<br>УБГД: 9010001085<br>РД: 5112494<br>Код: MBW<br>Утас: 75114444 |
| *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | Монголын хөрөнгийн бирж |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | Металл бус боловсруулах үйлдвэр буюу чулуун хөвөн дулаан тусгаарлах материалын үйлдвэр |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | 56,417,000 ширхэг |
| *Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр* | Ерөнхий нягтлан бодогч Б.Болортуяа<br>Маркетинг борлуулалтын ахлах менежер Т.Ууганцэцэг<br>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О.Билгүүн |

1 *Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангүй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/*

1.1 *Санхүүгийн байдлын үзүүлэлт*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| Хөрөнгө | | |
| Эргэлтийн хөрөнгө | 12,369,114,556.58 | 13,149,509,013.77 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 31,956,095,441.42 | 31,057,234,577.79 |
| **Нийт хөрөнгө** | **44,325,209,998.00** | **44,206,743,591.56** |
| Өр төлбөр ба эздийн өмч | | |
| Богино хугацаат өр төлбөр | 4,022,455,770.52 | 4,883,111,844.01 |
| Урт хугацаат өр төлбөр | 8,500,000,000.00 | 8,193,956,164.38 |
| Эздийн өмч | 31,802,754,227.48 | 31,129,675,583.17 |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | **44,325,209,998.00** | **44,206,743,591.56** |

1.2 *Орлогын тайлан*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| **Борлуулалтын орлого (цэвэр)** | **10,019,108,000.00** | **5,017,395,773.98** |
| Борлуулалтын өртөг | 6,736,199,000.00 | 3,118,764,584.81 |
| Нийт ашиг (алдагдал) | 3,282,909,000.00 | 1,898,631,189.17 |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **1,365,165,000.00** | **568,531,506.32** |
| Орлогын татварын зардал | 157,571,000.00 | 56,853,150.63 |
| **Татварын дараах ашиг (алдагдал)** | **1,207,594,000.00** | **511,678,355.69** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 0 | 0 |
| Орлогын нийт дүн | 1,207,594,000.00 | 511,678,355.69 |

1.3 *Өмчийн өөрчлөлтийн тайлан*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| Өмч | 5,641,700,000.00 | 5,641,700,000.00 |
| Халаасны хувьцаа | - | 0.00 |
| НТК | 20,509,765,227.48 | 20,509,765,227.48 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 3,121,609,000.00 | 3,121,609,000.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | - | - |
| ЭӨБХ | - | - |
| Хуримтлагдсан ашиг | 2,529,680,000.00 | 1,856,601,355.69 |
| **Нийт дүн** | **31,802,754,227.48** | **31,129,675,583.17** |

1.4 *Мөнгөн гүйлгээний тайлан*

| Үзүүлэлт | Эцсийн үлдэгдэл |
|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | -1,536,060,200.61 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 68,446,376.37 |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | -673,829,671.73 |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | -2,141,443,495.97 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 3,588,401,504.03 |

| | |
|---|---|
| 2 | *Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт* |
| | *2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 08 сарын ээлжит хурлаар хэлэлцэнэ.* |
| 3 | *Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт* |
| 3.1 | *Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/* |
| 3.2 | *Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц боломжийн үзүүлэлт* |
| 3.3 | *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрхи өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл* |
| 3.4 | *Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого* |
| 4 | *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол, зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл* |
| | Тайлант хугацаанд их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй. |
| 5 | *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл* |
| | Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй. |
| 6 | *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл* |
| 6.1 | *Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал* |

Монгол базальт ХК нь 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2024 оны 04 сарын 29-ны өдрийн 15.00 цагт Туушин зочид буудлын Сүлд танхимд 39,756,853 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 70.47 хувийн ирцтэйгээр хуралдсан.





Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэн 99 хувийн саналаар баталсан.

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай
2. Монгол базальт ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
3. Компанийн дунд хугацааны хөгжлийн бодлого боловсруулж батлах, хэрэгжилтийг нь хангах зөвшөөрөл олгох тухай

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын гаргасан тогтоолын хэрэгжилтийг ханган компанийн ТУЗ болон гүйцэтгэх захирлын баг зохион байгуулалттайгаар ажиллаж байна.

1 Хувьцаа эзэмшигчдийн бүтэц




2 Нөлөө бүхий хувьцаа эзэшигчид

| № | Нэр | Нийт хувьцаанд эзлэх хувь |
|---|---|---|
| 1 | Л.Ариунболд | 35.7% |
| 2 | П.Сайнбилэг | 13.3% |
| 3 | А.Энхгэрэл | 7% |
| 4 | А.Энхмаа | 7% |
| 5 | А.Энхжин | 7% |

| 6.2 | *Төлөөлөн удирдах зөвлөл* |
|---|---|




Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд дараах дөрвөн хороо ажиллаж байна.

- **Нэр дэвшүүлэх хорооны дарга:** П.Нямдорж Гишүүд : Г.Ганзориг, Ч.Зоригтбаатар
- **Аудитын хорооны дарга:** Ч.Зоригтбаатар Гишүүд: Б.Шаравсамбуу, Ш.Энхтөр
- **Цалин урамшууллын хорооны дарга**: Ш.Энхтөр, Гишүүд: П.Сайнбилэг, П.Нямдорж
- **Эрсдлийн удирдлагын хорооны дарга:** Ч.Зоригтбаатар, Гишүүд: Л.Ариунболд, А.Энхгэрэл Б.Шаравсамбуу , П.Нямдорж

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 5 гишүүн нь хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг хангаж байгаа бөгөөд компанийн сайн засаглалын бий болгох зорилгоор Залгамж халааны бодлого батлан хэзгжүүлж байна.

| 6.3 | *Компанийн засаглалын кодексын хэрэгжилт* |
|---|---|

Монгол базальт ХК нь 2023 оны жилийн эцсийн Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн өөрийн үнэлгээний тайлангаар нийт 72 оноонoос 71 оноо буюу 98.6%-аар үнэлсэнийг СЗХ-ны компанийн засаглал, комплайнсын хэлтэсээс хянан баталгаажуулж **69 оноо буюу 95.8** хувиар <u>“Засаглал хэвийн буюу эрсдэлгүй”</u> түвшинд үнэлсэн болно. Үүний үр дүнд Монгол базальт ХК нь компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн үнэлгээгээр нээлттэй хувьцаат компаниудын 9-д эрэмбэлэгдэх боллоо.

| 6.4 | *Ногдол ашгийн мэдээлэл* |
|---|---|

Монгол базальт ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 сарын 16 -ны өдрийн 03 дугаар тогтоолоор 2023 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 21 төгрөг буюу нийт 1,184,757,000 төгрөгийг

хувьцаа эзэмшигчдэд тараахаар шийдвэрлэсэн болно. Хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг 2024 оны 05 сарын 31-ний өдрийн дотор ҮЦТХТөв дэх дансаар тараан байршуулсан болно.

| | |
|---|---|
| *6.5* | *Хувьцааны арилжааны мэдээлэл* |

## ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

### ХУВЬЦААНЫ ХАНШ

**Хаалтын ханш** /2024.06.30/ **189.98₮**

**-2.02₮**

**Өмнөх ханш** /2023.12.31/ **192₮**

Тайлант хугацаанд хоёрдогч зах зээлд арилжаалагдсан нийт хувьцааны дээд ханш нь 206₮, доод ханш нь 170.42₮ бөгөөд 2024 оны эхний хагас жилийн хаалтын ханш 189.98₮ байлаа.

Тайлант хугацаанд үнэт цаасны хоёрдогч зах зээлд сард дунджаар 225 мянган ширхэг буюу тайлант хугацааны туршид нийт 1350 мянган ширхэг хувьцаа 246.1 сая төгрөгөөр арилжаалагдлаа.

*Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо*

| | | |
|---|---|---|
| | “Монгол базальт” ХК-ийн гүйцэтгэх захирал А.Энхгэрэл | |

*Мэдээлэл бэлтгэж хүргүүлсэн этгээдийн гарын үсэг огноо*

| | | |
|---|---|---|
| | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О.Билгүүн | |